

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019-10-18

Тендерийн дугаар: МРЦМ/201906668

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь “Бор-Өндөр” УБҮ-ийн Адаг-Баргилтын 35 КВ-ын 5 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам болон Адаг ЦДАШ-ыг Дархан ЦДАШ-д холбох техник эдийн засгийн үндэслэл боловсруулах (**тендерийн дугаар МРЦМ/201906668**) зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет” ТӨҮГ-ын 2019 оны худалдан авалтын төлөвлөгөөний хүрээнд Баргилтын уурхайг Бор-Өндөр-Дархан чиглэлийн 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамд, Бор-Өндөр-Адаг чиглэлийн ЦДАШ ашиглан холбох техник эдийн засгийн үндэслэл боловсруулж, цаашид тус ордыг 24 цагийн тасралтгүй ажиллагаатай, хэрэглэгчдийн шаардлага хангасан цахилгаан эрчим хүчийг хамгийн бага алдагдалтай найдвартай дамжуулахад чиглэгдэнэ.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг ирүүлнэ.

- ТӨХБАҮХАТухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан нотлох баримт
- Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2016, 2017, 2018 (Сүүлийн гурван жилд заагдсан зөвлөх үйлчилгээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн зураг төсөл, зөвлөх үйлчилгээний жагсаалт, гэрээний хуулбарыг гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ)
- Эрчим хүчний барилга угсралтын зураг төсөл, сүүлийн үеийн дэвшилтэт шийдлүүд бүхий зураг, төсөл боловсруулах чадвартай боловсон хүчинтэй байх
- Гадаад, дотоодын эрчим хүчний барилга угсралтын зураг төсөл судлах чиглэлээр танилцсан туршлагатай байх

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

4. Гадаадын этгээд оролцох эрхгүй.

5. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг санал хүлээн авах эцсийн хугацаанаас нэг хоногийн өмнө дор дурдсан хаягаар ажлын өдрийн 09-16 **цагийн** хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ **2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 14:00 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)** хаягаар ирүүлнэ.

**Монгол Улс, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, өөрийн байр**  
**Утас: 458401, Факс: 458380** Имэйл хаяг: **mailbox@monros.mn**